



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурвантэс сумын Шугшаа уул ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2023/19/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өмнөговь аймаг

2023 он

Хаан консалтинг аудит ХХК-ийн Гүйцэтгэх захирал:

Ч.Баярсайхан

Утас: 89000060 Цахим хаяг: bayaraach85@gmail.com

Аудитын менежер: Г.Ганцэцэг

Утас: 88883775 Цахим хаяг: jni.gantsetseg@gmail.com

Ахлах аудитор: Ш.Мөнхцэцэг

Утас: 99799039 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



### ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnogovi@audit.gov.mn

2023.03.15 № 233  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ГУРВАНТЭС СУМЫН ШУГШАА  
УУЛ ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Т.ЭРХЭМБАЯР ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Гурвантэс сумын Шугшаа уул ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Гурвантэс сумын Шугшаа уул ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор байгууллагын дүрмийн санг 4,428.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Хөрөнгө оруулалтуудыг бусад урт хугацаат өр төлбөр дансанд хуримтлуулан бүртгэж тайлагнадаг байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

016929230

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

/мянган төгрөгөөр/

	Үзүүлэлт	2021.12.31	2022.12.31
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	136,939.4	213,204.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,672,446.9	3,433,482.6
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,809,386.3</b>	<b>3,646,686.8</b>
	Өр төлбөрийн нийт дүн	1,973,080.1	1,956,353.0
	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,836,306.2	1,690,333.8
	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>3,809,386.3</b>	<b>3,646,686.8</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Борлуулалтын орлогын дүн	344,687.2	438,501.7
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөгийн дүн	658,841.1	735,154.7
	<b>Нийт ашиг алдагдал</b>	<b>(314,153.9)</b>	<b>(296,652.9)</b>
	Бусад орлого	225,066.3	251,361.5
	Ерөнхий ба удирдлагын зардал	87,650.9	96,184.1
	Бусад зардал	-	2,500.0
	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(1,996.9)
	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)</b>	<b>(176,738.5)</b>	<b>(145,972.4)</b>
	Орлогын татварын зардал	6,000.0	-
	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(182,738.5)</b>	<b>(145,972.4)</b>
	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>(182,738.5)</b>	<b>(145,972.4)</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,784,405.5	1,836,306.2
	Тайлант оны үр дүн	(182,738.5)	(145,972.4)
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>1,601,667.0</b>	<b>1,690,333.8</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	400,115.1	498,367.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	397,262.9	464,076.2
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>2,852.2</b>	<b>34,291.0</b>
	Мөнгөн зарлагын дүн	-	5,749.9
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>-</b>	<b>(5,749.9)</b>
	Мөнгөн зарлагын дүн		
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>		
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>2,852.2</b>	<b>28,541.1</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	94,285.6	65,744.5
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	65,744.5	94,285.6
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	Нийт орлого	569,753.5	690,186.0
	Нийт зардал	746,492.0	831,661.5
	<b>Нийт ашиг, алдагдал</b>	<b>(170,738.5)</b>	<b>(145,972.4)</b>

**Гурав. Аудитын илрүүлэлт:**

*Төлбөрийн акт*

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой төлбөрийн акт тавигдаагүй болно.

*Албан шаардлага*

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

*Зөвлөмж*

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		/сая төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ	1	6.4					1	6.4
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТШЗ								
ОНӨААТҮГ	1	2.5	1	2.5				
Дүн								
Нийт дүн	2	8.9	1	2.5			1	6.4

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	ОНӨААТҮГ					1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>					<b>1</b>			